



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/29/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Аудитор Г.Батмягмар**

Утас: 70373089 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	17
3.5.3 Нэмэлт төсөв .....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5.2 Албан шаардлага .....	19
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 50

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Дархан-Уул аймгийн Засаг даргын санаачилсан архины хамааралтай иргэдэд зориулсан төрийн үйлчилгээ үзүүлэх “Жаргалтай амьдрал төв” байгуулснаар орон нутгийн төсвөөс олгосон 295,583.6 мянган төгрөгийн санхүүжилтээс 96.4 хувийг зарцуулж, санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 59.1 хувиар өсжээ.

**Бусад асуудлын хэсэг**

4525020126

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын 58 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлснийг ХХҮЕГ-аас 88.1 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>87,252,291.25</u></b>	<b><u>106,986,401.28</u></b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	8,424,430.90	1,831,845.90
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	8,424,430.90	1,831,845.90
3121	<b>Төгрөг</b>	8,424,430.90	1,831,845.90
31218	Ахмадын сангийн харилцах	8,424,430.90	1,831,845.90
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	78,827,860.35	105,154,555.38
351	<b>Түүхий эд материал</b>	-	209,425.00
35130	Эм боох материал	-	209,425.00
354	<b>Хангамжийн материал</b>	64,007,860.35	94,345,130.38
35410	Бичиг хэргийн материал	266,100.00	1,386,100.00
35440	Түлш, шатах тослох материал	102,400.00	827,000.00
35450	Барилгын засварын материал	-	60,000.00
35470	Бусад хангамжийн материал	63,639,360.35	92,072,030.38
35600	Мал амьтад	14,820,000.00	10,600,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,429,549,431.85</u></b>	<b><u>1,880,136,521.53</u></b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,429,549,431.85	1,880,136,521.53
392	<b>Биет хөрөнгө</b>	1,195,311,431.85	1,322,132,464.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,359,638,962.86	1,244,626,813.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(255,905,979.96)	(199,551,727.31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,250,000.00	50,250,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,232,813.88)	(34,257,813.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	301,371,153.16	438,028,649.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(270,065,533.32)	(259,884,442.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	164,338,467.60	214,639,042.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(144,394,424.63)	(147,932,723.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	35,964,000.00	23,964,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,652,399.98)	(7,749,333.34)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	234,238,000.00	558,004,056.70
39301	Програм хангамж	79,625,000.00	80,477,068.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(75,125,000.00)	(78,867,011.30)
39303	Бусад биет бус хөрөнгө	229,738,000.00	556,394,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,516,801,723.10</u></b>	<b><u>1,987,122,922.81</u></b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,516,801,723.10</u></b>	<b><u>1,987,122,922.81</u></b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,516,801,723.10	1,987,122,922.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	436,714,893.47	763,370,893.47
51101	Өмч: - төрийн	436,714,893.47	763,370,893.47
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	818,477,358.20	1,067,239,015.24
51210	Өмнөх үеийн үр дүн	902,358,496.30	923,573,815.53
51220	Тайлант үеийн үр дүн	(83,881,138.10)	143,665,199.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	261,609,471.43	156,513,014.10
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,516,801,723.10</u></b>	<b><u>1,987,122,922.81</u></b>


## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,384,586,727.14</b>	<b>2,669,437,759.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>92,833,747.14</b>	<b>315,860,184.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	92,833,747.14	315,860,184.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	67,994,530.90	89,943,300.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,994,530.90	89,943,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	24,339,216.24	225,916,884.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	500,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,291,752,980.00</b>	<b>2,353,577,575.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,135,082,500.00	1,752,572,306.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,135,082,500.00	1,752,572,306.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	156,670,480.00	601,005,269.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,029,000.00	260,067,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,641,480.00	340,937,769.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,457,196,465.24</b>	<b>2,525,772,559.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,457,196,465.24</b>	<b>2,525,772,559.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,440,954,115.65	2,234,515,075.61
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,043,397,161.51	1,660,454,823.76
210101	Үндсэн цалин	499,671,583.44	851,845,418.59
210102	Нэмэгдэл	335,067,772.74	605,073,055.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	113,638,404.52	122,286,000.00
210104	Урамшуулал	95,019,400.81	81,250,350.01
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	146,640,397.33	207,486,719.95
210201	Тэтгэврийн даатгал	108,082,676.66	149,136,701.36
210202	Тэтгэмжийн даатгал	9,908,094.83	14,999,405.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,785,676.02	7,835,690.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,896,721.23	7,074,378.46
210205	Эрүүл мэндийн даатгал	18,967,228.59	28,440,544.46
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,808,690.57	29,278,491.94
210301	Гэрэл, цахилгаан	7,386,190.70	10,355,207.65
210302	Түлш, халаалт	5,935,426.64	14,451,510.78
210303	Цэвэр, бохир ус	2,487,073.23	4,471,773.51
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,308,420.00	22,071,040.00
210401	Бичиг хэрэг	9,459,900.00	7,367,200.00
210402	Тээвэр, шатахуун	8,944,180.00	11,744,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,363,840.00	2,543,940.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,194,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,046,300.00	415,800.00
210408	Бараа материал акталсны зардал	3,300,000.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	16,649,096.95	56,927,410.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,930.00	12,103,875.80
210502	Хоол, хүнс	16,555,166.95	44,823,535.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,683,799.00	15,972,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	-



210604	Урсгал засвар	13,183,799.00	15,972,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	567,400.00	4,962,000.00
210702	Дотоод албан томилолт	567,400.00	4,962,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	56,599,336.08	107,809,046.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,212,278.08	104,973,064.87
210803	Даатгалын үйлчилгээ	238,400.00	186,030.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	201,158.00	95,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,500.00	22,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	440,000.00
210807	Газрын төлбөр	925,000.00	2,092,452.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	122,299,814.21	129,553,142.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,348,200.00	16,357,447.97
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,670,000.00	1,760,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	106,281,614.21	111,435,694.32
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,242,349.59	291,257,483.68
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,450,000.00	248,824,585.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	79,074,238.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	164,491,297.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,450,000.00	5,259,050.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	9,736,043.64	27,945,666.57
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	22,393,069.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,736,043.64	92,882.22
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,459,714.79
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	5,056,305.95	8,448,232.11
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,056,305.95	8,448,232.11
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	6,039,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,039,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(72,609,738.10)</b>	<b>143,665,199.71</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	11,271,400.00	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,271,400.00	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(11,271,400.00)	
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(83,881,138.10)</b>	<b>143,665,199.71</b>



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	436,714,893.47	261,609,471.43	902,358,496.30	1,600,682,861.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>436,714,893.47</b>	<b>261,609,471.43</b>	<b>902,358,496.30</b>	<b>1,600,682,861.20</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(83,881,138.10)	(83,881,138.10)
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>436,714,893.47</b>	<b>261,609,471.43</b>	<b>818,477,358.20</b>	<b>1,516,801,723.10</b>
D01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>436,714,893.47</b>	<b>261,609,471.43</b>	<b>818,477,358.20</b>	<b>1,516,801,723.10</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	105,096,457.33	105,096,457.33
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>436,714,893.47</b>	<b>261,609,471.43</b>	<b>923,573,815.53</b>	<b>1,621,898,180.43</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	(105,096,457.33)	0.00	(105,096,457.33)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	326,656,000.00	0.00	0.00	326,656,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	143,665,199.71	143,665,199.71
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>763,370,893.47</b>	<b>156,513,014.10</b>	<b>1,067,239,015.24</b>	<b>1,987,122,922.81</b>




## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,359,747,510.90</u></b>	<b><u>2,443,520,875.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>67,994,530.90</b>	<b>89,943,300.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	67,994,530.90	89,943,300.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	67,994,530.90	89,943,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,994,530.90	89,943,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,291,752,980.00</b>	<b>2,353,577,575.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,135,082,500.00	1,752,572,306.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,135,082,500.00	1,752,572,306.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	156,670,480.00	601,005,269.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,029,000.00	260,067,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,641,480.00	340,937,769.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,342,205,981.00</u></b>	<b><u>2,440,663,560.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,342,205,981.00</b>	<b>2,440,663,560.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,325,963,631.41</b>	<b>2,149,406,076.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,059,379,258.00	1,661,299,683.30
210101	Үндсэн цалин	551,592,456.53	866,978,171.32
210102	Нэмэгдэл	305,933,663.93	604,198,008.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	96,828,488.76	109,837,996.26
210104	Урамшуулал	105,024,648.78	80,285,506.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	125,035,721.84	206,641,860.41
210201	Тэтгэврийн даатгал	86,425,078.44	151,036,733.82
210202	Тэтгэмжийн даатгал	9,922,632.20	13,946,099.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,785,346.72	7,029,000.11
210204	Ажилгүйдлийн даатгал	1,900,240.75	6,926,066.03
210205	Эрүүл мэндийн даатгал	19,002,423.73	27,703,960.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,808,690.57	29,278,491.94
210301	Гэрэл, цахилгаан	7,386,190.70	10,355,207.65
210302	Түлш, халаалт	5,935,426.64	14,451,510.78
210303	Цэвэр, бохир ус	2,487,073.23	4,471,773.51
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,918,157.97	38,209,930.00
210401	Бичиг хэрэг	8,017,000.00	7,697,200.00
210402	Тээвэр, шатахуун	9,169,580.00	12,468,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,363,840.00	2,543,940.00
210404	Ном, хэвлэл	-	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,212,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,155,537.97	15,450,090.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	15,500,484.95	60,942,960.80

ХТ05439@9022899

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,930.00	11,886,810.80
210502	Хоол, хүнс	15,406,554.95	43,750,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	5,305,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,340,850.00</b>	<b>22,581,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,634,000.00	4,220,000.00
210602	Тавилга	-	1,790,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	596,200.00	2,584,900.00
210604	Урсгал засвар	10,110,650.00	13,986,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>567,400.00</b>	<b>4,962,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	567,400.00	4,962,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>65,990,215.08</b>	<b>115,398,764.87</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,603,157.08	112,562,782.87
210803	Даатгалын үйлчилгээ	238,400.00	186,030.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	201,158.00	95,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,500.00	22,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	440,000.00
210807	Газрын төлбөр	925,000.00	2,092,452.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,422,853.00</b>	<b>10,090,585.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,432,853.00	6,992,585.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,990,000.00	3,098,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,242,349.59</b>	<b>291,257,483.68</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,450,000.00</b>	<b>248,824,585.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	79,074,238.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	164,491,297.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,450,000.00	5,259,050.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>9,736,043.64</b>	<b>27,945,666.57</b>
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	22,393,069.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,736,043.64	92,882.22
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,459,714.79
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,056,305.95</b>	<b>8,448,232.11</b>
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,056,305.95	8,448,232.11
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>6,039,000.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,039,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>17,541,529.90</u></b>	<b><u>2,857,315.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>9,117,099.00</b>	<b>9,449,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,117,099.00</b>	<b>9,449,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>9,117,099.00</b>	<b>9,449,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,117,099.00	9,449,900.00



6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(9,117,099.00)</u>	<u>(9,449,900.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,424,430.90	(6,592,585.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	8,424,430.90
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,424,430.90	1,831,845.90



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,847,067,400.00</b>	<b>1,820,029,654.22</b>	<b>(27,037,745.78)</b>	<b>98.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,847,067,400.00	1,820,029,654.22	(27,037,745.78)	98.5
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,592,828,500.00	1,571,205,069.22	(21,623,430.78)	98.6
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,281,249,500.00	1,260,735,883.93	(20,513,616.07)	98.4
210101	Үндсэн цалин	671,101,600.00	750,549,584.19	79,447,984.19	111.8
210102	Нэмэгдэл	394,279,900.00	323,962,796.68	(70,317,103.32)	82.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	112,280,000.00	105,937,996.26	(6,342,003.74)	94.4
210104	Урамшуулал	103,588,000.00	80,285,506.80	(23,302,493.20)	77.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	157,496,600.00	157,496,554.98	(45.02)	100.0
210201	Тэтгэврийн даатгал	110,315,600.00	110,315,554.98	(45.02)	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	11,795,200.00	11,795,200.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,897,600.00	5,897,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,897,700.00	5,897,700.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	23,590,500.00	23,590,500.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,826,300.00	16,147,350.53	(678,949.47)	96.0
210301	Гэрэл, цахилгаан	7,578,000.00	8,430,178.04	852,178.04	111.2
210302	Түлш, халаалт	6,118,000.00	5,380,463.48	(737,536.52)	87.9
210303	Цэвэр, бохир ус	3,130,300.00	2,336,709.01	(793,590.99)	74.6
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,755,000.00	20,739,680.00	(15,320.00)	99.9
210401	Бичиг хэрэг	3,943,000.00	3,544,600.00	(398,400.00)	89.9
210402	Тээвэр, шатахуун	8,554,000.00	8,515,000.00	(39,000.00)	99.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,593,800.00	687,940.00	(905,860.00)	43.2
210404	Ном, хэвлэл	500,000.00	50,000.00	(450,000.00)	10.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	421,200.00	-	(421,200.00)	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,743,000.00	7,942,140.00	2,199,140.00	138.3
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	27,965,000.00	27,965,000.00	-	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	206,646.00	(293,354.00)	41.3
210502	Хоол, хүнс	25,935,000.00	22,958,354.00	(2,976,646.00)	88.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,530,000.00	4,800,000.00	3,270,000.00	313.7
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	28,746,700.00	28,746,700.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,249,600.00	13,438,900.00	(1,810,700.00)	88.1
210602	Тавилга	-	1,790,000.00	1,790,000.00	

ХТ03438@0022899

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,794,900.00	2,584,900.00	(210,000.00)	92.5
210604	Урсгал засвар	10,702,200.00	10,932,900.00	230,700.00	102.2
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,962,000.00	3,962,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	3,962,000.00	3,962,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	55,827,400.00	55,411,899.78	(415,500.22)	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,037,700.00	54,025,917.78	(11,782.22)	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	186,100.00	186,030.00	(70.00)	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141,500.00	95,300.00	(46,200.00)	67.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,200.00	22,200.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	999,900.00	642,452.00	(357,448.00)	64.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	254,238,900.00	248,824,585.00	(5,414,315.00)	97.9
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	254,238,900.00	248,824,585.00	(5,414,315.00)	97.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	84,276,000.00	79,074,238.00	(5,201,762.00)	93.8
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	164,491,600.00	164,491,297.00	(303.00)	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,471,300.00	5,259,050.00	(212,250.00)	96.1
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,847,067,400.00	1,820,122,536.44	(26,944,863.56)	98.5
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,757,207,400.00	1,730,179,236.44	(27,028,163.56)	98.5
122005	Улсын төсвөөс санхүүжих	1,757,207,400.00	1,730,179,236.44	(27,028,163.56)	98.5
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	89,860,000.00	89,943,300.00	83,300.00	100.1
120010	Туслах үйл ажиллагааны орлого	89,860,000.00	89,943,300.00	83,300.00	100.1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	45.00	44.00	-	97.8
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	8.00	7.00	-	87.5
620004	Гэрээт ажилтан			-	



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>581,058,322.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>581,058,322.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	581,058,322.10
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	400,563,799.37
210101	Үндсэн цалин	116,428,587.13
210102	Нэмэгдэл	280,235,212.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,900,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	49,145,305.43
210201	Тэтгэврийн даатгал	40,721,178.84
210202	Тэтгэмжийн даатгал	2,150,899.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,131,400.11
210204	Ажилгүйдлийн даатгал	1,028,366.03
210205	Эрүүл мэндийн даатгал	4,113,460.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,131,141.41
210301	Гэрэл, цахилгаан	1,925,029.61
210302	Түлш, халаалт	9,071,047.30
210303	Цэвэр, бохир ус	2,135,064.50
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,470,250.00
210401	Бичиг хэрэг	4,152,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,953,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,856,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,507,950.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>32,977,960.80</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,680,164.80
210502	Хоол хүнс	20,792,196.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	505,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,285,000.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	231,000.00
210604	Урсгал засвар	3,054,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>59,986,865.09</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,536,865.09
210807	Газрын төлбөр	1,450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,498,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,098,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>581,058,322.10</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>581,058,322.10</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	258,023,050.03
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	323,035,272.07



### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Нийгмийн халамжийн бодлого, бүх төрлийн үйлчилгээг хүртээмжтэйгээр хэрэгжүүлж, зорилтот бүлгийн иргэдийг Халамжаас-хөдөлмөр эрхлэлт рүү чиглүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, төрийн үйлчилгээг ялгаваргүй, жигд хүргэхэд чиглэгдэх, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага байна.

Тус газар нь “Нийгмийн халамжийн үйлчилгээг хүн амын тодорхой бүлгийн онцлог хэрэгцээнд тулгуурлан хүртээмжтэй хүргэж, Хөдөлмөрийн зах зээл дэх тэгш боломж, таатай орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулж өрхийн амьжиргааг дээшлүүлж ажиллах” зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль*
- *Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор цалингийн доод хэмжээг шинэчлэн баталсан.*

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 470,321.2 мянган төгрөгөөр буюу 31.0 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,424.4	1,831.8	(6,592.6)
Авлага	-	-	-
Бараа материал	78,827.8	105,154.5	26,326.7
Үндсэн хөрөнгө	1,429,549.4	1,880,136.5	450,587.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,516,801.7</b>	<b>1,987,122.9</b>	<b>470,321.2</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,516,801.7	1,987,122.9	470,321.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,516,801.7</b>	<b>1,987,122.9</b>	<b>470,321.2</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,831.8 мянган төгрөг нь ахмадын сангийн зарцуулаагүй үлдэгдэл байна.

Бараа материалын өсөлт нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 128,340.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 102,013.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна. Оны эцэст үлдсэн 105,154.5 мянган төгрөгийн бараа материал нь байгууллагын ахмадын Гүнд амралтын газрын болон бусад хангамжийн материалууд байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс өссөн нь аймгийн Засаг даргын захирамжаар 153,595.0 мянган төгрөгийн “Жаргалтай амьдрал төв”-ийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, хөрөнгийн дахин үнэлгээгээр 326,656.0 мянган төгрөгийн газар, 72,321.9 мянган төгрөгийн ХХҮЕГ-аас компьютер, тоног төхөөрөмжийг бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 9,449.9 мянган төгрөгөөр машин, тоног төхөөрөмж бэлтгэсэн, аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/313 тоот захирамжаар 59,556.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 2023 оны 01-А/275 тоот захирамжаар 115,012.1 мянган төгрөгийн 3 дугаар брак байрыг тус тус акталсан, 111,435.7 мянган төгрөгийн элэгдэл тооцсон зэргээс шалтгаалжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,987,122.9 мянган төгрөг болж 470,321.2 мянган төгрөгөөр өссөн нь газрыг дахин үнэлгээ хийж биет бус хөрөнгөөр бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг 1,668,615.4 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс 1,598,615.4 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 70,000.0 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөн, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг 1,367,224.7 мянган төгрөгөөр баталсныг тайлант оны 12 дугаар сард Засгийн газрын 2024 оны 128, 241 дүгээр тогтоолын дагуу цалингийн өсөлт, хөдөө орон нутгийн нэмэгдэл, зах зээлийн үнийн өсөлттэй холбоотойгоор 1,847,067.4 мянган төгрөг болгон нэмж тодотгосон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх 1,847,067.4 мянган төгрөгийн 95.1 хувийг улсын төсвөөс, 4.9 хувийг байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,752,572.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагаанаас 89,943.3 мянган төгрөгийн орлого олж, нийт 1,842,515.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Урсгал үйл ажиллагаанд 1,820,029.7 мянган төгрөг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 22,393.0 мянган төгрөг, өөрийн орлогоос төвлөрүүлсэн 92.9 мянган төгрөг, нийт 22,485.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71902- Нийгмийн халамж	1,576,117.9	1,549,080.2	(27,037.7)	98.3
1.1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	1,232,019.0	1,210,405.2	(21,613.8)	98.2
1.2	80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	89,860.0	89,850.4	(9.6)	99.9
1.3	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	254,238.9	248,824.6	(5,414.3)	98.2
2	72102 – Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	270,949.5	270,949.5	0.00	100.0
2.1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	270,949.5	270,949.5	0.00	100.0
<b>Нийт дүн</b>		<b>1,847,067.4</b>	<b>1,820,029.7</b>	<b>(27,037.7)</b>	<b>98.3</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус газрын бүтэц, орон тоог Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалаар 46 орон тоо баталснаас гүйцэтгэлээр 44 албан хаагч ажилласан байна. Тайлант онд ахмадын сангийн харилцах данснаас 6,592.6 мянган төгрөг зарцуулжээ. Батлагдсан төсвөөс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 55,827.4 мянган төгрөг төлөвлөж, 99.2 хувийг зарцуулсан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орон нутгийн төсвөөс орон нутгийн нэмэгдэлд 260,067.5 мянган төгрөг, “Жаргалтай амьдрал төв”-ийн зардалд 296,383.6 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас судалгааны ажил болон амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 43,054.2 мянган төгрөг, дэлхийн банкны санхүүжилттэй ажлын байрыг нэмэгдүүлэх жижиг зээлийн төсвийн сургалтын зардалд 1,500.0 мянган төгрөг, нийт 601,005.3 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 19,863.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд 13 албан хаагчийн орон тоотой, 25 ортой, ажилгүй, архинд донтох эмгэгтэй болон тэнэмэл амьдралтай иргэдийг эмчилж, илаарьшуулах, нийгэмшүүлэх, хөдөлмөр эрхлүүлэх, нийгмийн идэвхтэй амьдралд оруулах, амьдралын чанарыг сайжруулах эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлэх зорилготой

“Жаргалтай амьдрал төв” байгуулжээ. Тус төв нь 2024 онд нэг удаа 21 хоногийн турш үргэлжлэх эмчилгээ, үйлчилгээнд зорилтот бүлгийн 18-55 насны 176 /39 эмэгтэй/ иргэнийг хамруулсан байна. Үүнээс 134 хүн хэвтэн эмчлүүлж, 42 хүн амбулаторийн үзлэг, эмчилгээнд хамрагдаж 286,893.8 мянган төгрөг зарцуулсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн цалингийн зардалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Батмягмар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн 1,847,067.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 18,470.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны цахим нэгдсэн хуудаст байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,864.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 529 тоот албан бичгээр ирүүлснийг шалгахад 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,910.8	1	1,910.8	100
Албан шаардлага	2	4,953.5	2	4,953.5	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>6,864.3</b>	<b>3</b>	<b>6,864.3</b>	<b>100</b>

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 326,656.0 мянган төгрөгийн газрыг орлогод авахдаа өмнөх үеийн үр дүн дансыг нэмэгдүүлж тайлагнасан алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Энэ нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, санхүүгийн тайлангийн “Толилуулга”, “Ангилал” зэрэг батламж мэдэгдэлтэй нийцээгүй тул засгийн газрын оруулсан капитал дансанд бүртгүүлж залруулав.

Мөн аудитаар нийт 8,398.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх 1 зөвлөмж хүргүүлээ.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

#### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

#### 5.3 Зөвлөмж

##### 1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

###### 1. Илрүүлэлт:

Тус байгууллага 7 албан хаагчид мөнгөн шагнал олгохдоо цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-тай тус тус нийцэхгүй байна.

###### 2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, цаашид дээрх алдааг давтан гаргахгүй байх

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Дээрх зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Газрыг орлогод авахдаа өмнөх үеийн үр дүн дансыг нэмэгдүүлсэн байна	1	326,656.0	-	-	1	326,656.0	1	326,656.0	-	-	-	-
Дүн	1	326,656.0	-	-	1	326,656.0	1	326,656.0	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
7 албан хаагчид мөнгөн шагнал олгохдоо цалингийн зардлаас олгосон	1	8,398.0	-	-	-	-	1	8,398.0	-	-	-	-
Дүн	1	8,398.0	-	-	-	-	1	8,398.0	-	-	-	-

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.